уламжлалтай билээ. Түүнчлэн “Монгол Улсын Хилийн тухай хууль”-ийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т “Хилийн хяналтыг явуулахад шаардлагатай барилга, байгууламж, талбай, тэдгээрийн тоног төхөөрөмжийг орон нутгийн болон зам харилцааны байгууллага барьж байгуулсны дараа Улсын хил хамгаалах байгууллага нь хилийн хяналтын бусад байгууллагатай хамтарч тухайн боомтыг нээж ажиллуулна”, мөн хуулийн тавдугаар бүлэг, гучин наймдугаар зүйл, “Төрийн захиргааны төв байгууллагын үүрэг”-ийн 5-д “Төрийн захиргааны төв байгууллага, аж ахуй нэгж нь улсын хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, Улсын хил хамгаалах байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлж, улсын хил хамгаалалтад шаардагдах бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангана” хэмээн тус тус заажээ. Үүнээс үзэхэд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад Төрийн захиргааны төв байгууллагуудын шууд оролцоо дэмжлэг туслалцаа чухал ач холбогдолтой байна.

Хол ойрыг холбосон энэхүү сэдвээ үүгээр өндөрлөж, та бүхний аль хэдий нь мэдэх олон зүйлийг нуршиж үнэт цагийг тань үрсэн бол хүлцэл өчье.

*БХИС-ийн Ерөнхий цэргийн тэнхимийн багш,*
*цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор,*
*хурандаа И.Сэржхүү*

## ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД ТӨРИЙН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Хил залгаа улстай хиллэж байгаа хилийн сумдын нутаг дэвгэрийг **хил орчмын нутаг дэвсгэр** гэж үзэх ба сумд нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэгтэй. өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засагтай нийгмийн цогцолбор юм. Энэ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 25 гаруй хувь буюу, хилийн 14 аймгийн 73 сумын нутаг дэвсгэрийг эзэлж байна.

Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн бүс нутагт хангагдсан байдлаар тодорхойлогдоно.

Хил орчмын нутаг дэвсгэрт онцгой нөхцөл байдал үүссэн үед тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсгийн нэг болно.

Онцгой байдлын үеийн хил хамгаалалт гэдгийг улсын хилийн зурвас, бүсэд (хил орчмын нутаг дэвсгэрт) гамшигт аюулт үзэгдэл тохиолдох, эмх замбараагүй байдал үүсэх, иргэд бөөнөөр хил нэвтрэхийг завдах, алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа явагдах, өдөөн хатгалга, зэвсэгт халдлага, түрэмгийлэл үйлдэгдэх нөхцол байдал бий болсон үед хил хамгаалах байгууллагаас явуулах цогц үйл ажиллагаа гэж ойлгоно хэмээн Монгол Улсын хил хамгаалах 11 дүрэм (Хилийн застав)-д тодорхойлсон байна.

Онцгой байдлын үеийн хил хамгаалалт нь олон төрлийн нөхцөл байдлыг агуулсан өргөн цар хүрээтэй асуудал болох нь дүрэмд тодорхойлсноос харагдаж байгаа бөгөөд үүнээс улсын хилээр зэвсэггүй бөон иргэд цомөрсөн үед хпл

хамгаалах байгууллагаас харилцан ажиллагаатай байгууллагуудын дэмжлэгтэйгээр түүнийг таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх талаар авч үзье. Үүнд:

Улсын хилээр цөмөрсөн зэвсэггүй бөөн иргэдийн ажиллагааг таслан зогсоох ажиллагааны зарчим нь зэвсэг хэрэглэхгүй байх, зэвсэггүй бөөн иргэдийн ажиллагааг зэвсэгт мөргөлдөөн, будлиан болгон хувиргахгүй байхад онцгойлон анхаарч ажиллана. Энэ ажиллагааг эхлээд тухайн зөрчил гарсан хэсэг хариуцсан заставын хүчээр, дараа нь хөрш заставуудын бэлтгэл хүч, хил орчмын бэлтгэл хүчээр явуулж, шаардлагатай нөхцөлд ХХЕГ-ын даргын бэлтгэл хүч, тухайн чиглэлд байрласан ТЕГ, цагдаа, онцгой байдал, зэвсэгт хүчний анги салбараас харилцан ажиллагааны төлөвлөгөөний дагуу дэмжлэг үзүүлэх хүчийг оролцуулж, түүнчлэн зарим чиглэлд хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг оролцуулж болно.

Заставын бие бүрэлдэхүүн отрядын даргын тушаалаар улсын хилийн тодорхой хэсгийг хааж, хариуцсан хэсэгт улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаална.

Хилийн отрядын оператив жижүүр хилийн заставаас мэдээ авмагц захирагч, штабын дарга, хилийн албаны дарга нарт яаралтай мэдээлж, штабын даргын заавраар хилийн отрядын бэлтгэл хүчийг албаны бэлэн байдалд оруулах дохио өгнө.

Улсын хилийн хариуцсан хэсэгт бөөн иргэд нэвтрэн орж ирсэн үед отрядын дарга хүч нэмэгдүүлсэн хамгаалалтыг зохион байгуулж, урьдчилсан ажиллагааны болон харилцан ажиллагааны төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж хилийн бүс, зурваст уг иргэдийг тогтоон барих шийдвэрийг гаргаж, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гаргасан шийдвэрийг дээд штабт илтгэнэ.

Энэ шийдвэрийн дагуу уг ажиллагаанд оролцох харилцан ажиллагаатай байгууллага, салбар харилцан ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж, түүнийг үндэслэн ажиллана.

Улсын хил бөөнөөр нэвтэрсэн иргэдийн үйлдлийг таслан зогсоохоор гаргасан отрядын даргын шийдвэр нь уг иргэдийг хилийн бүс, зурваст тогтоон барьж, улмаар хэсэгчлэн хуваан түрж Монгол Улсын нутаг дэвсгэрээс гарган улсын хилийг хаахад чиглэнэ.

Улсын хилээр иргэд бөөнөөрөө хил даван ирсэн үйлдлийг таслан зогсоохын тулд Хилийн отряд нь дараах бүлгүүдийг томилон ажиллуулна. Үүнд:

- тогтоон барих бүлэг;
- бүслэн хязгаарлах бүлэг;
- хэсэгчлэн хуваах бүлэг;
- хөөн гаргах бүлэг;
- галын бүлэг;
- сөрөг суртал ухуулгынбүлэг;
- магадлан шалгах, баримтжуулах бүлэг;
- эрлийн бүлэг;
- бэлтгэл хүч тус тусболно.

Энэ бүлгүүд нь улсын хил цөмрөн Монгол Улсын нутагт бөөнөөр орж ирсэн иргэдийн асуудлыг шийдвэрлэхээр явуулж байгаа ажиллагааны журмын элементүүд болох ба тус бүр өөр өөрийн онцлогтой үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

**Тогтоон барих бүлэг** ньхил нэвтрэн ирсэн иргэдийг нутгийн гүн рүү нэвтрүүлэхгүй тухайн заагт саатуулан тогтоох үүрэгтэй бөгөөд тухайн зорчил гарсан хэсгийг хариуцсан хилийн заставын бэлтгэл хүчнээс бүрдэх бөгөөд отрядын бэлтгэл хүч, хөрш заставын хүч хүрэлцэн ирэх хугацаанд хил нэвтрэн орж ирсэн иргэдийг барьж байна.

**Бүслэн хаах хязгаарлах бүлэг** хил зөрчсөн зэвсэггүй бөөн иргэдийг өөрийн нутагт тарах болон нэмж хүн хойноос нь хилээр орох боломжоо олгохгүйгээр тухайн бүсэд хөдөлгөөнийг хязгаарлаж цаашид бүслэлтээ нягтруулах, багасгах үүрэгтэй. Энэ үүргийг биелүүлэх хүч хэрэгсэл нь Хилийн отрядын бэлтгэл хүчнээс томилогдоно, түүнийг хүч нэмэгдүүлэх, бүслэн хаах нягтрал, гүн, найдвартай байдлыг хангах зорилгоор ХХЕГ-ын бэлтгэл хүчнээс болон харилцан ажиллаатай ЗХ-ний анги, салбар, орон нутгийн хил хамгаалалтад туслах хүчний гишүүдээс дэмжлэг авч ажиллана.

Энэ бүлгийн бүрэлдэхүүнд орсон ЗХ-ний дэмжлэг үзүүлэх салбар нь бүлэг болон зохион байгуулагдаж эсвэл салбараараа отрядын даргаас зааж өгсөн заагийг эзлэн бүслэн хязгаарлах бүлгийн бүрэлдэхүүнд, тухайн бүлгийн удирдагчид захирагдан түүний өгсөн үүрэг зааврын дагуу ажиллана.

**Хэсэгчлэн хуваах бүлэг** бүслэгдсэн иргэдийг хэсэгчлэн хувааж, ажиллагааг нь саармагжуулах, гол толгойлогчид, эсэргүүцэгчдийг бусдаас ялган тусгаарлах үүрэгтэй бөгөөд тэднийг түрэн улсын хилээр буцаан гаргах ажиллагааны нөхцөлийг хангах чиг үүрэгтжй ажиллана.

Энэ үүргээ биеүүлэх үед зэвсэггүй бөөн иргэдэд зэвсэг хэрэглэхгүйг онцгой анхаарч, тэдгээрийн эрүүл мэндэд хохирол учруулахгүй дуут дохио өгөн урагшлах болон бусад энгийн хэрэгсэл ашиглаж болно.

Зэвсэгт хүчний дэмжлэг үзүүлэхээр ирсэн салбар бүлэг нь хилийн отрядын бэлтгэл хүчтэй хамтран дээрх үүргийг биелүүлж болно.

**Хөөн гаргах бүлэг нь** хуваагдаж тусгаарлагдсан хүмүүсийг хэсэг хэсгээр нь нутаг дэвсгэрээсээ хөөн зайлуулах үүрэгтэй бөгөөд зэвсэг хэрэглэхгүйгээр цэргийн хүчээр түрж улсын хилээр буцаан гаргана. Галын бүлэг нь эдгээр бөөн иргэдийн дотроос зэвсэг хэрэглэсэн тохиолдолд тухайн этгээдийг цаг тухайд нь илрүүлж аюулгүй болгох буюу устгах үүрэгтэй бөгөөд хилийн отряд, харилцан ажиллагаатай ЗХ-ний анги салбараас томилогдсон мэргэн буучдаас бүрдэнэ.

**Сөрөг суртал ухуулгын бүлэг нь** ухуулах хуудас чанга яригчийн тусламжтайгаар хөдөлгөөнтэй ба суурин байрлалаас ухуулга сурталчилгаа явуулан тэдгээрийг сэтгэл зүйд нөлөөлөх үүрэгтэй бөгөөд хилийн отрядын соёл сурталчилгаа, мэдээллийн албаны ажилтангуудаас томилно.

**Магадлан шалгах, баримтжуулах бүлгийг** саатуулагдсан этгээдүүдийг хэн болохыг тогтоох, хууль бус үйлдлийг баримтжуулах, эд мөрийн нотлох баримт бүрдүүлэх үүрэгтэйгээр хилийн тагнуулын ажилтанг, боломжоотой бол тухай орон нутгийг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын оролцоотойгоор томилон тус тус ажилуулна. Иргэд бөөнөөр хил зөрчсөн ажиллагааг таслан зогсоох үед хилийн отрядын дарга ЗХ-ний дэмжих салбарыг оролцуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд харилцан ажиллах төлөвлөгөөг тодотгож, цагийн байдлыг үндэслэн ашиглах хувилбаруудыг тогтооно.

Хил давж ирсэн зэвсэггүй бөөн иргэдийн үйлдлийг таслан зогсоох ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр ЗХ-ний харилцан ажиллагаатай ангиас томилогдсон салбар нь тогтоон барих бүлэг, бүслэн хязгаарлах бүлэг, хэсэгчлэн хуваах бүлэг, хөөн гаргах бүлэг, бэлтгэл хүч, галын бүлэгүүдийн аль нэгэнд дангаараа болон эсвэл хилийн отряд заставаас томилогдсон бүлгүүдийг хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгэнэ.

Хилийн отрядын дарга, штаб хөрш улсаас бөөн иргэд улсын хилийг хууль бусаар нэвтрэн орж ирсэн үед тэдний үйлдлийг таслан зогсоох ажиллагааг зохион байгуулахдаа дараах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- үүргээ судлах;
- хилийн цагийн байдлыг үнэлэх;
- бөөн иргэдийн хууль бус үйлдлийг таслан зогсоох, улсын хилийг хүч нэмэгдүүлэн хамгаалах шийдвэр гаргах;
- салбаруудад шнйдвэрээ хүргэх;
- харилцан ажиллагаа, холбоог зохион байгуулах;
- хил орчмын дэглэмийг сахиулах;
- бүх талын хангалтыг зохион байгуулах зэрэг ажлууд орно.

Хилийн отрядын даргаас боөн иргэдийн хууль бусаар улсын хилийг нэвтрэн орж ирсэн ажиллагааг таслан зогсоох ажиллагааг зохион байгуулахдаа дараах онцлогуудыг харгалзах шаардлагатай байдаг. Хилийн отрядын хариуцсан хэсэгт үүссэн цагийн байдал, дээд удирдлагаас хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах талаар өгсөн үүрэг, улсын хилийг найдвартай хамгаалах, улсын хилээр нэвтрэн орж ирсэн бөөн иргэдийг түрэн гаргаж хилийг хаахад шаардагдах хүч хэрэгслийг тооцон хөрш хилийн отряд, харилцан ажиллагаатай зэвсэгт хүчний анги салбарын томилгоот бүлгүүд, орон нутгийн хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийн оролцоо, боломж зэргийг харгалзан үзнэ.

Хилийн цагийн байдлыг үнэлэхдээ хөрш улсад бий болсон тогтворгүй байдал, дайсагнасан ажиллагааны шинж тэмдэг, зорилго, зэвсэглэсэн бүлэглэлийг ашиглаж болзошгүй хүч хэрэгсэл, чиглэл, улсын хилээр нэвтрэн орж ирсэн бөөн иргэдийн өдөөн хатгах болзошгүй зорилго зэргийг тооцно.

Хилийн заставын байршил хилийн зөрчил гарсан хэсгийн алслалт, бэлтгэл хүчний хүрэлцэн ирэхэд шаардагдах хугацаа, ажиллагаанд эерэг ба сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг тогтооно.

Хил орчмын оршин суугчдын байршил, нягтрал, хил залгаа улсын иргэдээс манай улсад хандах хандлага, өдөөн хатгаж болзошгүй ажиллагааны хэлбэр, чиглэл, хил орчмын иргэдийн ажил үйлдвэрлэл эрхлэлт, бөөн иргэд хил нэвтрэн орж ирсэн үед хил хамгаалалтад үзүүлэх нөлөө, хил орчмын нутаг дэвсгэр дахь эрүүгийн нөхцөл байдал, хил орчмын дэглэмийг зөрчиж болзошгүй үйлдэл зэргийг судална.

Газар орны байдал, хил зөрчин орж ирсэн иргэдийн нуугдаж болох газар орон, цэргийн хяналтанд хамруулах, хамгаалалтын заагуудыг тогтооход газар орны үзүүлэх нөлөө, хорлон сүйтгэх, алан хядах бүлгийн хилийн застав, харуул болон ажиллагаа болж байгаа районд дөхөн ирж болох газрууд, усны эх булаг, өнгөлөн далдлалтын шинж чанар зэргийг анхаарна.Бөөн иргэдийг түрэн гаргах ажиллагаандаа хэрэглэгдэх тусгай хэрэгслүүд тэдгээрийг хэрэглэх журам зэргийг

тодотгоно. Улсын хилээр нэвтрэн орж ирсэн бөөн иргэдийг түрэн гаргах ажиллагааны бодлогод дараах зүйлүүд тусгагдсан байна. Үүнд:

Хил хамгаалах хэлбэр, заагууд, үндсэн хүчээ төвлөрүүлэх чиглэл, хүч хэрэгслийн нягтрал, хугацаа, бусад хэсгийг хамгаалах арга, цэргийн хяналт зохион байгуулах арга, бэлтгэл хүчний бүрэлдэхүүн, байрлал, бэлэн болох хугацааг заана.

Улсын хилээр бөөн иргэд нэвтрэн орж ирсэн иргэдийг түрэн гаргах үед харилцан ажиллагааг сайн зохион байгуулах шаардлагатай байдаг.

Хилийн отрядын салбар, нэгжүүд болон хөрш отрядууд, хил хамгаалахад туслах хүч, орон нутаг дахь хууль хяналтын байгууллагууд, ЗХ-ний анги, салбаруудтай харилцан ажиллагаа, холбоо зохион байгуулах төлөвөлөөг нэгдсэн байдлаар хилийн отрядын штабаас боловсруулж гүйцэтгэгч нарт амаар болон бичгээр хүргүүлж, уг ажиллагаанд хэрэглэгдэх нэгдсэн таних тэмдэг, нэр, дохиог урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөний дагуу тодотгох байдлаар зохион байгуулна.

Улсын хил нэвтрэн орж ирсэн бөөн иргэдийн үйлдлийг таслан зогсоох ажиллагааг явуулах үед удирдлагыг отрядын дарга өөрийн биеэр явуулах бөгөөд зарим тохиолдолд удирдлагын тусгай бүлгийг байгуулна.

Зэвсэггүй бөөн иргэдийн өдөөн хатгалгыг таслан зогсоох ажиллагааны агуулга нь зэвсэггүй бөөн иргэдийн араар улсын хилийг хааж, ар талаас нь таслах, тэдгээрийг бүслэх, хэсэгчлэн хувааж бүслэх, хуваагдан бүслэгдсэн бөөн иргэдийг хөөж түрэн гаргаж, улсын хилийг хаахад оршино, ажиллагааны үед зэвсэг хэрэглэхгүй байхад онцгой анхаарна, суртал ухуулга хийх, баримтжуулах ажиллагааг сайн зохион байгуулж явуулна.Зэвсэггүй бөөн иргэдийн удирдаж байгаа толгойлогчтой ярилцлага хийх, түүнийгээ баримтжуулах шаардлагатай.

**Дүгнэлт**

1. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогын хүрээнд хил хамгаалах байгууллагаас орон нутгийн засаг захиргааны болон үндэсний аюулгүй байдал хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжүүлэх, хил хамгаалах албандаа тухайн байгууллагуудаас дэмжлэг авах, харилцан туслах, туршлага судалж албандаа нэвтрүүлэх асуудал чухал байр суурийг эзэлнэ.

2. Харилцан ажиллагааны үр дүн, амжилт нь тайван цагт тодорхой хугацаанд, тухайлбал жилд 1-ээс доошгүй удаа харилцан ажиллах төлөвлөгөөг хамтарсан команд штабын сургалт явуулж тодотгол хийдэг журам тогтоож хэрэгжүүлсээр хангагдана гэж үзэж байна. ХСИС-ийн Удирдлагын сургууль байгуулагдсанаас хойш анхны КШС-ыг “Хил орчмын нутаг дэвсгэрт тусгай чиг үүрэг бүхий зарим байгууллагуудын харилцан ажиллагаа” сэдвээр явуулж байгаа нь уг асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөх загвар, санал, дүгнэлт гаргах болно.

3. Тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагаа, хамтын ажиллагааны талаар дагнан гаргасан эрх зүйн зохицуулалт хийх акт байхгүй байгаа, өөр өөрийнхөө байгууллагын явцуу хүрээнд гаргасан эрх зүйн актуудад ёс төдий дурдагдсан байдал нь хариллцан ажиллагаа, хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Энэ байдлыг хууль санаачлан боловсруулж батлуулах эрх бүхий УИХ-ын гишүүдийн сонорт хүргэн, мэргэжлийн талаар санал, зөвлөмж дэвшүүлэх хэлбэрээр

ойлгуулж даруй шийдвэрлэх нь шаардлагатай байна. Харилцан ажиллагааны үед тухайн үүссэн нөхцөл байдлыг эхнээс нь эцэс хүртэл удирдах байгууллага нь тодорхой бус байгаа зэргийг тогтоон нарийвчлан авч үзэх нь чухал юм.

4. Харилцан ажиллагаа нь албан үүргийн дагуу эрх зүйн актуудад үндэслэгдэн зайлшгүй гүйцэтгэх үүрэг, зааврыг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжддэг харин хамтын ажиллагаа нь гэрээ, хамтран ажиллах санамж бичгийн хэлбэрээр хэрэгждэг олон хэлбэртэйгээрээ болон агуулгын хувьд ялгаатай асуудал гэж үзэх оновчтой байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа Б.Сайнболор*

## ОЛОН УЛСЫН ЦЭРЭГ-УЛС ТӨРИЙН БАЙДАЛ НЬ МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД нөлөөлөх нь

**Нэг. Цэрэг-улс төрийн байдал, түүнний орнөлт**

Цэрэг-улс төрийн байдал гэдэг ойлголт (ухагдахуун) нь тухайн бүс нутагт оршин тогтнож байгаа улс, орнуудын улс төр, нийгэм, эдийн засгийн ашиг сонирхлын нөлөөллөөр ямагт хөдөлгөөнтэй буюу өрнөлттэй байдаг бөгөөд энэ чанараараа байнга бусдын анхаарлын төвд байж ямар нэг хэмжээний эрсдэл дагуулж явдаг онцлогтой. Энэхүү эрсдэл нь тухайн улс болон бусад улсуудын хувьд ямар нэг хэмжээгээр эерэг, сөрөг үйл явцыг бий болгох бөгөөд үүнийхээ үр дүнд нэг талынх нь ашиг сонирхлыг хангаж, нөгөө талынх нь ашиг сонирхолд хохирол авчирч байдаг. Энэ утгаараа олон улсын түвшинд ч, Зүүн хойд Азийн бүс нутгийн хувьд ч цэрэг-улс төрийн байдал XX зууны эхэн үеэс өнөөг хүртэл байнгын хөдөлгөөнтэй байж түүнийхээ хөгжлийн явцад агуулга, шинж чанарын хувьд ихээхэн өөрчлөгдөж байсан байна.

Монгол Улсын оршин буй зүүн хойд Азийн бүс нутаг нь энэ хугацаанд байнга хувьсан өөрчлөгдөж улс, үндэстэн хоорондын үзэл бодол, байр суурийн зөрчил, сөргөлдөөний талбар байсан бөгөөд өдгөө ч уг үйл явц эрсдэл дагуулсан асуудал хэвээр байсаар байна. Өөрөөр хэлбэл зүүн хойд Азийн орнуудын улс төрийн байгууламж, үзэл суртлын ялгаа, хүйтэн дайнаас улбаатай харилцан бие биедээ үл итгэдэг явдал бүс нутагт маргааныг зохицуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ авахад гол саад тотгор болсоор байна.

Хэдийгээр газар зүйн байрлал болон улс төрийн нөлөөллөөрөө зүүн хойд Азид дэлхийн их гүрнүүдийн дөрөв нь, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүний гурав нь, дэлхийн хамгийн том эдийн засагтай орнуудын гурав нь оршдог боловч тус бүс нутагт цэрэг-улс төрийн байдал тогтворгүй, үл ойлголцол, мөргөлдөөн гарч болзошгүй үзэл бодол, байр суурийн зөрчилдөөний аюул, эрсдэл бүхий талбар хэвээр байна.

Уг аюул, эрсдэл нь үйл явцынхаа зорилго, учир шалтгаан, шинж чанар, хамрах хүрээнээсээ хамааран төрөл бүрийн агуулга, хэлбэрээр гарч болзошгүй болжээ. Түүнчлэн учирч болзошгүй аюул буюу эрсдэлийн тухай бидний төсөөлөлд